



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/115

Арвайхээр

**Хөрөнгө зарцуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2019-2020 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 285 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2020 оны 01 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Онцгой комиссоос 2019 оны 11 дүгээр сард аймгийн өвөлжилтийн нөхцөлд хийсэн үнэлгээгээр 16 суманд эрсдэлийн түвшин их, 2 сум дунд, 1 сум бага эрсдэлтэй гарсан тул зудын эрсдэлийг хохирол багатай даван туулах, Засгийн газрын 285 дугаар тогтоолын хавсралтад заасан өвс, тэжээлийн нөөцийг бэлтгэх зорилгоор аймаг, сумдын өвс, тэжээлийн аюулгүй нөөцөд Ховд аймгийн Засаг даргын Тамгын газраас 3870 боодол нарийн өвсийг, 1300 боодол нарийн өвсийг Зүүнбаян-Улаан сумын иргэн Ж.Зоригтбаатар (ГО86100575), 1000 боодол нарийн өвсийг Арвайхээр сумын иргэн Ц.Зундуй (ЙВ84111515) нартай худалдан авах гэрээ байгуулах, сумдад хуваарилах, хүлээлгэн өгөх, малчдад олгох ажилд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т даалгасугай.

2. Аймгийн өвс тэжээлийн нөөцөд худалдан авсан 2300 боодол өвсний үнэ, тоо ширхэгийг хавсралтаар баталсугай.

3. Өвсний нөөц бүрдүүлэхэд шаардагдах тэжээлийн үнэ 32.700.000 (гучин хоёр сая долоон зуун мянга) төгрөгийг аймгийн гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100253

Аймгийн Засаг даргын 2020 оны 03  
дугаар сарын 18-ны өдрийн 4115 дугаар  
захирамжийн хавсралт



ХУДАЛДАН АВСАН ӨВСНИЙ ҮНЭ, ТОО ШИРХЭГ

Д/д	Өвс нийлүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэн	Нэг бүрийн үнэ /мянган төгрөг/	Нийлүүлсэн өвсний тоо /ширхэг/	Нийт үнэ /мянган төгрөг/
1	Ховд аймгийн Засаг даргын Тамгын газраас	3.1	3870	12.000.0
2	Арвайхээр сумын иргэн Ц.Зундуй /нарийн өвс/	9.0	1000	9.000.0
3	Зүүнбаян-Улаан сумын иргэн Ж.Зоригтбаатар /нарийн өвс/	9.0	1300	11.700.0
	Нийт		6170	32.700.0

-оОо-